

Шинээр үүсгэн байгуулагдах нам:

Намыг шинээр бүртгэх үйл ажиллагаа

/шалгах хуудас- 3/

Үйл ажиллагаа	Хууль, журамд нийцсэн эсэхийг шалгах шалгуур	Зөрчил илэрсэн эсэх
УТНТХ-ийн 11 дүгээр зүйл. Улс төрийн нам үүсгэн байгуулах Намыг зохион байгуулах Их Хурал /цаашид “үүсгэн байгуулах хурал” гэх/-аар үүсгэн байгуулна. (11.1)		
Нам үүсгэн байгуулах Их хурлыг зарлан хуралдуулах	- Үүсгэн байгуулагчийн мэдээлэл; - Намыг үүсгэн байгуулах хурлын бэлтгэлийг хангасантай холбоотой мэдээлэл, баримт;	
	Хугацаа: - Хурал зохион байгуулах газар, хугацааг нэг сарын өмнө төлөөлөгчдөд мэдэгдсэн эсэхтэй холбоотой баримт. (11.2)	
	Төлөөлөгч: - Намыг үүсгэн байгуулах хуралд оролцсон Төлөөлөгчдийн мэдээлэл: ○ Тухайн намын гишүүнээр элссэн байх; ○ Орон нутгаас төлөөлөх төлөөлөгчдийг оролцуулсан байдал /аль аймгийн төлөөлөл болох / (11.3) холбогдох баримтууд;	
	Намын гишүүд: - Намын зорилго, үзэл баримтлал, намын хөтөлбөр, дүрмийг хүлээн зөвшөөрч, сайн дурын үндсэн дээр нам үүсгэн байгуулахаар эвлэлдэн нэгдсэн 801 иргэний талаарх мэдээлэл: ○ Монгол Улсын иргэн; ○ 18 насанд хүрсэн; ○ Өөр намын харьяалалгүй; ○ Өөр хүнээр төлөөлүүлээгүй байх; хуулийн шаардлагыг тус тус хангана. (13.2.3, 14.4.3)	
Хурлын явц	- Хурлын ирцийн мэдээлэл;	

	- Хурлын дэг баталсан, хуралдаан даргалагч, Тооллогын комиссын бүрэлдэхүүн томилсон гэх хурлын явцад гарсан шийдвэр; - Хуралдааны тэмдэглэл; - Хуралдааны явцыг баримтжуулсан баримт /фото зураг, аудио видео бичлэг зэрэг байгаа эсэх/;	
Хэлэлцэх асуудал	Үүсгэн байгуулах хурлаар хэлэлцвэл зохих асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэсэн эсэх: - Намын бүтэн болон товчилсон нэр, бэлгэ тэмдгийн загварыг батлах; (11.4.1) - Намын хөтөлбөр, дүрмийг батлах; (11.4.2) - Төлөөллийн төв, гүйцэтгэх төв болон хяналтын байгууллагын бүрэлдэхүүнийг сонгон байгуулах, түүний зохион байгуулалтын бүтэц, эрх, үүргийг тогтоох; (11.4.3) - Намын даргыг сонгох; (11.4.4) - Нам үүсгэн байгуулсан тухай шийдвэрийг батлах. (11.4.5)	
Шийдвэр гаргалт	Хурлаас гарсан шийдвэрийг албажуулсан байдал, хүчин төгөлдөр байх нөхцөл: - Эрх бүхий этгээд гарын үсэг зурсан эсэх; - Асуудлыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэсэн эсэх; - Санал хураалт ямар хэлбэрээр явагдсан; - Санал хураалтын дүнг баталгаажуулсан эсэх /саналын хуудас, дүнгийн протокол/; - Хурлыг цахимаар хийсэн тохиолдолд шийдвэр гаргасантай холбоотой баримтууд байгаа эсэх;	
УТНтХ-ийн 12 дугаар зүйл. Улс төрийн намыг бүртгүүлэх өргөдөл гаргах <u>Намыг үүсгэн байгуулсныг бүртгүүлэх тухай өргөдлийг Улс төрийн намын бүртгэл хөтлөх журам (“Хавсралт 1”, “Хавсралт 1А”)-д заасны дагуу гаргана.</u>		
Өргөдөл гаргах УТНтХ- 2.1, 12.2	Үүсгэн байгуулах хурал хийж, шийдвэр гаргасан өдрөөс хойш 30 хоногийн дотор өргөдлөө ирүүлэх; (12.1) • Хүндэтгэн үзэх шалтгааны улмаас дээрх хугацааг хэтрүүлсэн тохиолдолд уг хугацаа дууссанаас хойш 30 хоногийн дотор (12.5) Өргөдөл гаргах эрхтэй этгээдийг тодруулах: - Намын даргаар сонгогдсон этгээд (12.1) - Эсхүл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч; (12.1)	

Өргөдөлд хавсаргах баримт бичиг УТНтХ-12.3, 12.4	- Нам үүсгэн байгуулах тухай шийдвэр, уг шийдвэрт хуралдаан даргалагч, эсхүл тэргүүлэгчид гарын үсэг зурсан байна; (12.3.1) - Намын бүтэн болон товчилсон нэрийн бичвэр, намын нэр, бэлгэдэл, далбааны зургийг тайлбарын хамт; (12.3.2) - Намын дүрэм; (12.3.3) - Намын хөтөлбөр; (12.3.4) - Намын гүйцэтгэх төв байгууллага оршин байгаа газрын хаягийн мэдээлэл; (12.3.5) - Намын 801 гишүүний бүртгэл /ургийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, регистрийн дугаар, оршин суугаа газрын хаяг, утасны дугаар, цахим шуудангийн хаяг, гарын үсэг/; (12.3.6) - Намын дарга, намын санхүүгийн асуудал хариуцсан ажилтны бүртгэл /ургийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, регистрийн дугаар, оршин суугаа газрын хаяг, утасны дугаар, цахим шуудангийн хаяг, гарын үсэг, иргэний үнэмлэхийн хуулбар/; (12.3.7) - Намын хөрөнгийн жагсаалт, намд өгсөн хандивын жагсаалт, намыг үүсгэн байгуулахтай холбогдон гарсан зардлын эх үүсвэр зэргийг тусгасан намын хөрөнгийн мэдээлэл; (12.3.8) - Нам үүсгэн байгуулах хурлын тов, байршлыг энэ хуулийн 11.2-т заасны дагуу мэдэгдэж, зарласан тухай баримт; (12.3.9) - Шаардлагатай тохиолдолд итгэмжлэл. (12.3.10)	
	Намын хөрөнгийн мэдээлэл дараах зүйлийг тусгаж, тайлагнана: (12.4) - Намыг бүртгүүлэх өргөдөл гаргахаас өмнө тухайн намын аль нэг үүсгэн байгуулагчийн нэр дээр банкны түр данс нээнэ; - Намын хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө; - Мөнгөн болон мөнгөн бус хөрөнгө; - Гишүүний татвар; - Хандив; - Намыг үүсгэн байгуулахтай холбогдсон зардал.	
	Хүндэтгэн үзэх шалтгааны улмаас өргөдөл гаргах хугацааг хэтрүүлсэн тохиолдолд холбогдох баримтыг ирүүлнэ. (12.5)	

Шинээр үүсгэн байгуулагдсан намын Дүрэм, хөтөлбөрийг Улс төрийн намын тухай хууль /шинэчилсэн найруулга/-д нийцсэн эсэхийг “шалгах хуудас-2”-т заасны дагуу шалгана.